



ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 12 сарын 03 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Хүүхэд хамгааллын чиглэлээр
баримтлах бодлого, чиглэл батлах тухай

Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.1, 16.4.2 дахь заалтууд, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичгийг нэгдүгээр, байгууллагад эцэг эхийн зөвлөл байгуулж ажиллах зөвлөмжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг, эцэг эхийн зөвлөл байгуулж ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг төр, хувийн хэвшлийн байгууллагуудад даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтийг хангаж, төр хувийн хэвшлийн байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар/О.Алтансүх/-т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД,
ТЭРГҮҮН



Ү.ХҮРЭЛСҮХ

Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018
оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар
тогтоолын 1. дүгээр хавсралт



ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

Энэхүү баримт бичиг нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бүх байгууллагууд, хуулийн этгээдэд хамаарна.

НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР:

1. Хүүхэд: 18 нас хүртэлх хүн¹
2. Хүүхэд хамгаалал²: Нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц мэргэшсэн үйл ажиллагаанаас бүрдэнэ.
3. Хүүхдэд ээлтэй байгууллага: Бие махбод, сэтгэл санааны, бэлгийн болон үл хайхрах хүчирхийллээс (байдлаас) хүүхдийг хамгаалах үзэл санаа, үйл ажиллагааг өөрийн байгууллагын бүх түвшинд нэвтрүүлсэн, дадал болгосон, дотоод журамдаа тусгасан, байгууллагын соёлд нэвт шингээсэн байгууллага.
4. Хүүхэд хамгааллын бодлого: Хүүхдэд учрах эрсдэл, хор нөлөөнөөс сэргийлж, хамгаалахын тулд байгууллага бүр анхаарал тавьж байгааг нотолсон баримт бичиг. Үүнд хүүхэд бүрт аюулгүй, эерэг орчин бүрдүүлэхийн тулд байгууллага, ажилтнууд, сайн дурын идэвхтнүүд болон бусад холбогдох хүмүүс юуг анхаарах ёстойг тусгасан байна
5. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд³: Эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхэд
6. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл⁴: Санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамтыг хэлнэ. Хүчирхийллийн хэлбэр:
 - бие мах бодын хүчирхийлэл
 - сэтгэл санааны хүчирхийлэл
 - бэлгийн хүчирхийлэл
 - үл хайхрах
7. Бие махбодийн хүчирхийлэл: Хүүхдийг өөрийн эрхшээлдээ байлгах, давамгайл байдал тогтоох, шийтгэх зорилгоор хэн нэгэн этгээд хүч хэрэглэн хүүхдийн биед халдсаныг эсхүл энэхүү нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй зэргийг хэлнэ.
8. Үл хайхрах: Зохистой хоол унд, хувцас, орон байр, эмнэлгийн тусламж боловсрол эзэмших зэрэг хүүхдийн үндсэн хэрэгцээг хангаж чадахгүй байхыг хэлнэ.
9. Сэтгэл санааны хүчирхийлэл: Асран хамгаалагчийн зүгээс хүүхдийг үнэ цэнэгүй, согогтой, чамд хэн ч хайргүй, чамтай хамт байхыг хэн ч хүсэхгүй гэж ойлгуулах, айлган сүрдүүлэх, хэл амаар доромжлох, загнах, гутаах зэрэг үйлдэл юм.
10. Бэлгийн хүчирхийлэл: Хүүхдийн халдашгүй дархан байдал, бэлгийн эрх чөлөөг зөрчсөн бэлгийн харилцаанд оруулахаар завдсан, оруулсан, бэлгийн болон садар самууны шинжтэй бусад үйлдэлд уруу татсан, шаардсан, энэхүү нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй зэргийг хэлнэ.
11. Хүүхдийг садар самуунд ашиглах⁵: Бэлгийн амьдралыг харуулан дүрслэн бичсэн бичлэг, видео бичлэг, зураг бүтээхдээ хүүхдийг оролцуулах үйлдэл

¹ НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцийн 1 дүгээр заалт

² МУ-ын Хүүхэд хамгааллын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг

³ МУ-ын Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт

⁴ МУ-ын Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалт

⁵ МУ-ын Эрүүгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.8 дахь хэсэг

⁶ МУ-ын Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалт

12. Мөлжлөг: Хүүхдийн эмзэг байдлыг ашиглан тэднийг хүнд хөдөлмөр эрхлүүлэх, садар самуун болон бусад эрсдэлт үйл ажиллагаанд уруу татан ашиг олох үйлдэл
13. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ⁶: Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасган зохицуулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх үе шат бүхий үйл ажиллагаа

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын нийт хүн амын гуравны нэгийг эзэлж байгаа 0-18 хүртэлх насны хүүхдийн хуулиар олгогдсон эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрх, эрх чөлөөг хангах, аж байдлыг сайжруулахад Засгийн газраас байнга анхаарч ирсэн билээ.

Хүүхэд хамгааллын ойлголтын хүрээнд НҮБ-ын Хүүхдийн Эрхийн тухай Конвенц болон Монгол Улсын нэгдэн орсон бусад холбогдох олон улсын гэрээ, конвенц, мөн түүнчлэн үндэсний хууль тогтоомжоор 18 нас хүрээгүй хүн бүрийн эрхийг хангах асуудлыг авч үздэг.

Манай Улс сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд Нэгдсэн Үндэстний Байгууллагын /цаашид "НҮБ" гэх/ Хүүхдийн эрхийн тухай конвенц, түүний 3 удаагийн нэмэлт протоколыг соёрхон баталж, үндэсний хууль тогтоомжийг конвенцийн зарчим, үзэл санаанд нийцүүлэх, НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн удаа дараагийн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд анхааран ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газраас хүүхдийн сайн сайхан байдлын төлөө хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааны үр нөлөөг үнэлж, улмаар сүүлийн 3 жилд хүүхдийн эрх ашгийг хамгаалсан хуулиудад эрх зүйн томоохон шинэчлэлийг хийж Хүүхдийн эрхийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудын шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурал баталлаа. Мөн Хүүхэд хамгааллын тухай хуулийг шинээр батлан хэрэгжүүлж байна. Эрх зүйн шинэчлэлийн дүнд хүүхдийг нийгмийн бүх орчинд дарамт, хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах байдлаас ангид байлгах, тэдний хамгаалагдах эрхийг хуулиар баталгаажуулан хүүхдийн эсрэг хүчирхийллийг бүх орчинд хуулиар хориглосон дэлхийн 49 дэх орон боллоо.

Хүүхэд хамгааллын тухай хуулиар гэр бүл, боловсролын салбар, эрүүл мэндийн үйлчилгээ, хэвлэл, мэдээлэл, цахим орчин, олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээн дэх хүүхэд хамгааллын асуудлыг хуульчлан баталлаа.

Хүүхдийн эрх, хамгааллын асуудлаарх хууль, эрх зүйн орчин сайжирч, боловсрол, эрүүл мэнд, хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэж, тодорхой үр дүн гарч байгаа хэдий ч хүүхдийн эсрэг хүчирхийлэл, зөрчлийн нөхцөл байдал түгээмэл байна.

НҮБ-ын Хүүхдийн Эрхийн тухай конвенцид хүүхэд аливаа дарамт, хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах явдлаас хамгаалуулах эрхтэй бөгөөд насанд хүртлээ эцэг эх, гэр бүл ба төрийн онцгой халамж, хамгаалалтанд байх шаардлагатай болохыг заасан байдаг.

Хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь үйл ажиллагаа явуулахдаа хүүхдийн язгуур эрхийг эн тэргүүнд хангахыг эрхэмлэж, хүүхэд эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж, байгууллага бүр Хүүхэд

хамгааллын бодлого, дүрэм боловсруулж, мөрдөх, эцэг эхийн зөвлөл байгуулж ажиллах шаардлагатай байна.

Иймд Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн эрхийн конвенц, Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн үзэл санаатай уялдуулан байгууллага, салбар бүрт мөрдөх Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичгийг боловсруулан баталлаа.

Хоёр. Зорилго

2.1. Байгууллага, хуулийн этгээд нь өөрийн ажил үйлчилгээ болон ажилтан албан хаагчдаараа дамжуулан гэр бүл, нийгмийн хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхэдтэй зүй бус харилцах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх, хамгаалахад хүлээсэн үүрэг, хариуцлагаа биелүүлэх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

Гурав. Үндсэн зарчмууд

3.1. Хүүхдийн эрхийг дээдлэх.

Хүүхдийн эрх, язгуур эрх ашиг, тэдний аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж, хүүхдийн эрхийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэн үзнэ. Хүүхдийн эрхийг дээдлэх үүргээ биелүүлж, хүүхдийн эрхийг дэмжихэд хүчин чармайлт гаргахад анхаарна.

3.2. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг огт хүлээн зөвшөөрөхгүй байх:

Хүүхэдтэй зүй бус харилцах, хүүхдийн эсрэг хүчирхийллийн аливаа хэлбэртэй хэзээ ч эвлэрэхгүй байж хүүхдийн аюулгүй байдалд эрсдэл учруулах хүнийг хүүхэдтэй ажиллах, хамт олны дунд байхыг хүлээн зөвшөөрөхгүй.

3.3. Эрсдэлийг тооцох, урьдчилан сэргийлэх.

Аливаа үйл ажиллагаанд хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах байдалд оруулж болзошгүй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлж, эрсдэлийг бууруулах, учирч болзошгүй хор нөлөө, сөрөг үр дагаварыг багасгах, арилгахад байнга анхаарч ажиллана.

Дөрөв. Хамрах хүрээ

4.1. Энэхүү баримт бичиг нь байгууллага хуулийн этгээдийн бүх үндсэн болон гэрээт ажилтан, албан хаагч, ажилчин, сайн дурын ажилтан, дадлагажигч ажилтан, оюутан, зочид, судлаач, хамтран ажиллах байгууллага болон хувь хүмүүст хамаарна.

Тав. Хэрэгжүүлэх заавар

5.1. Байгууллага бүр хүүхэд хамгааллын асуудлаар ажиллах Эцэг эхийн зөвлөлийг байгуулж ажиллах бөгөөд дараах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлнэ.

- Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх, сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах,
- Хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой мэдээлэл өгөх, хүлээн авах,
- Хүүхэд эрсдэлт нөхцөлд байгааг мэдсэн, ажигласан, таамагласан тохиолдолд гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн байгууллага, цагдаагийн байгууллагад холбон зуучлах, мэдээлэх арга хэмжээ авч ажиллана.

5.2 Зохион байгуулалт

5.2.1. Удирдах ажилтан, албан тушаалтны төлөөлөл бүхий Эцэг эхийн зөвлөл байгуулна. Энэхүү зөвлөл нь байгууллагын хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөж, зохион байгуулна. Бодлогыг нийт ажилтан болон бусад хүмүүст харагдахуйц газар байнга байрлуулан сурталчилна.

5.3 Урьдчилан сэргийлэх

5.3.1. Сургалт сурталчилгаа, мэргэжил арга зүйн дэмжлэг

5.3.1.1. Ажилтнуудад хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн харилцааны чиглэлээр сургалт явуулна.

5.3.1.2. Хүүхэд хамгаалал хүүхдийн эрхийн талаарх хууль эрх зүйн баримт бичгийн талаар мэдээлэл өгч, сургалт явуулна.

5.3.1.3. Хүүхдэд ээлтэй байгууллага байх талаар хамт олонтойгоо нээлттэй ярилцаж, хүүхэдтэй холбоотой аливаа зөрчлийг мэдээлэх соёл төлөвшүүлнэ.

5.3.1.4. Хүүхэд хамгааллын асуудлаар мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж мэргэжил, арга зүйн дэмжлэг туслалцаа авна.

5.4. Ажилтан шалгаруулан ажилд авахад дараах асуудлыг анхаарах

5.4.1. Хүүхдэд хор хохирол учруулж болзошгүй хүнийг ажилд орохоос урьдчилан сэргийлэхийн тулд хүүхэдтэй зүй бусаар харилцаж байсан эсэхийг ажилтан шалгаруулах үзүүлэлтэд заавал оруулна.

5.4.2. Ажилд шинээр орох гэж буй хүний тухай эрх бүхий байгууллагаас хүүхдийн эрхийн зөрчил гаргаж байсан эсэх талаар тодорхойлолт авна.

5.4.3. Ажилд орох хүсэлт гаргагчийг хамгийн сүүлд ажиллаж байсан байгууллагаас болон хоёроос дээш жилийн хугацаанд таних хоёр хүнээс зан байдлын тодорхойлолт гаргуулсан байхыг шаардана. (Гэр бүлийн гишүүн байж болохгүй). (Тодорхойлолтыг гаргуулахдаа "Хавсралт 2"-д өгсөн загварыг ашиглаж болно.)

5.5. Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэм баримтлах

5.5.1. Нийт ажилтнууд болон шинээр ажилд орж байгаа ажилтан, албан хаагч Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэмтэй танилцан гарын үсэг зурж гэрээ байгуулна. (6-р зүйл. Хавсралт 1).

5.5.2. Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийг зөрчсөн ажилтанд зөвлөх, зааж сургах, сахилгын арга хэмжээ авах, үүрэгт ажлаас нь өөрчлөх, түдгэлзүүлэх, чөлөөлөх эсвэл хуулийн хүрээнд шийдвэрлүүлэхээр ажлын гэрээнд тусгана.

5.6. Эрсдэлийг бууруулах

5.6.1. Байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаа нь хүүхдэд хор хөнөөл учруулж болзошгүй эрсдэл байгаа эсэхэд тогтмол үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах, арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

5.6.2. Өөрийн үйлдвэрлэл, үйл ажиллагаандаа хүүхдийн эрхийг ханган аюулгүй орчныг бүрдүүлэн ажиллана.

5.7. Зөрчлийг мэдээлэх, мэдээлэл хүлээн авах үүрэг

5.7.1. Ажилтан бүр хүүхдийн эсрэг аливаа хүчирхийлэл, мөлжлөгийн талаар байгууллагын удирдлага, Эцэг эхийн зөвлөлд мэдээлэх үүрэгтэй.

5.7.2. Байгууллага эцэг эхийн зөвлөл хүүхэд хамгааллын зөрчлийг мэдээлэх, мэдээлэл хүлээн авах үүрэгтэй.

5.7.3. Байгууллагын ажилтан болон бусад хүмүүс хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийг зөрчсөн болон зөрчсөн байж болзошгүй үйлдэл, зан үйлийн талаар мэдээлэх.

5.7.4. Байгууллага дээр болон байгууллагаас явуулж буй үйл ажиллагааны үеэр хүүхэд хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үл хайхрах байдалд өртсөн буюу өртсөн байж болзошгүй талаар мэдээлэх, хүлээн авах

5.7.5. Орон нутаг, тодорхой газар хүүхдийн аюулгүй байдал алдагдсан, хүүхэд хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн болон өртсөн байж болзошгүй талаар мэдээллийг Хүүхэд хамгааллын тухай хуулийн дагуу өгнө.

5.7.6. Мэдээлэгчийн нууцлалыг хадгалан, мэдээлэгчийн аюулгүй байдлыг хангана.

5.8. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, холбон зуучлах

5.8.1. Байгууллага нь хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх мэдээллийн мөрөөр ажиллахдаа хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хамгаалахын тулд хүчин чармайлтаа гарган ажиллана.

5.8.1.1. Шуурхай үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээнд холбон зуучлахдаа уг үйл ажиллагааны улмаас хүүхдийг дахин хохирогч болгохгүй байхад онцгой анхааран ажиллана.

5.8.1.2. Бүх мэдээллийн нууцыг хадгалж, асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэнэ.

5.8.1.3. Мэдээллийг хүлээн авсан Эцэг эхийн зөвлөл байгууллагын удирдлагатай зөвлөж тухайн нөхцөлд тохируулан дараагийн алхмыг хэрэгжүүлнэ.

5.8.1.3. Хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюул заналхийлсэн нөхцөл байдал үүссэн тохиолдолд хүүхдийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд хангана.

5.8.2. Хэрэв тухайн асуудал нь гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй бол дараах арга хэмжээг авна.

5.8.2.1. Хуулийн байгууллага болон орон нутгийн эрх бүхий хүүхэд хамгааллын байгууллага, хамтарсан багт яаралтай мэдэгдэнэ.

5.8.2.2. Хуулийн байгууллага болон орон нутгийн эрх бүхий хүүхэд хамгааллын байгууллагаас нь хэргийн явцын болон хэрхэн шийдвэрлэсэн талаарх эцсийн мэдээллийг авдаг байна.

5.8.3. Хэрэв тухайн асуудал нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол дараах арга хэмжээг авна.

5.8.3.1. Буруутай этгээдийн асуудлыг байгууллагын дүрэм, журмын дагуу шийдвэрлэнэ.

5.8.3.2. Хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх шаардлагатай бол орон нутгийн хүүхэд хамгааллын байгууллага болон мэргэжлийн байгууллагын үйлчилгээнд холбон зуучилна.

Зургаа. Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэм

6.1. Ёс зүйн дүрмийн гол зорилго нь хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалахад орших бөгөөд байгууллагын ажилтны зүгээс хүүхэд хамгааллын хувьд эрсдэлтэй, зохисгүй зан үйл гаргахгүй байхад чиглэнэ.

Зөвшөөрөх	<ul style="list-style-type: none"> ✓ Хүүхдэд дээрэнгүй хандахгүй байх ✓ Харилцааны зөв үлгэр дууриалал үзүүлэх ✓ Хүүхдийг хүмүүжүүлэхдээ бие махбодийн шийтгэл хэрэглэхгүй байх, хүмүүжлийн эерэг аргыг ашиглах ✓ Хүүхдийн хувийн нууцыг задруулахгүй байх, хүндэтгэлтэй хандах ✓ Хүүхдийг ашигласан садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг бусад зүйлсийг хэрэглэхгүй байх, ийм зүйлсээс татгалзах ✓ Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг хүлээн зөвшөөрдөггүй, мэдээллийг нуун дарагдуулдаггүй соёлыг байгууллага, хамт олонд төлөвшүүлэх ✓ Аливаа үйл ажиллагааг явуулахдаа хүүхдийн амь нас, эрүүл мэндэд хохирол үзүүлж болзошгүй бүхий л эрсдэлийг тооцох, сэргийлэх ✓ Хүүхдийн дунд гарч болзошгүй дээрэлхэлт, дарамт, хүчирхийллээс сэргийлэх ✓ Хүүхдийг хөдөлмөрийн, бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргийн золиос болохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах
Хориглох	<ul style="list-style-type: none"> ☒ Хүүхдийг цохих, зодох, тусгаарлах зэргээр бие махбодын хүчирхийлэл үйлдэх ☒ Хүүхдийг гутаах, ичээх, доромжлох, дорд үзэх, нэр хоч өгөх, сэтгэл зүйн дарамт учруулах зэргээр сэтгэл санааны хүчирхийлэл үйлдэх ☒ Хүүхэдтэй бэлгийн харилцаанд орох, бэлгийн харилцаанд уруу татах, биеийг үнэлүүлэх зэргээр бэлгийн хүчирхийлэл үйлдэх ☒ Хүүхдийг бэлгийн харилцаанд өдсөн, садар самуунд уруу татсан тоглоом тоглох, шалиг үг яриа ярих зэргээр биеэ авч явах, бусдад тийм боломж олгох ☒ Хууль бус эсвэл хүүхдэд аюултай нөхцөл байдалд орсон тохиолдолд түүнийг тоохгүй орхих ☒ Хүүхдийн дэргэд хараал хэлэх, бүдүүлэг үг хэрэглэх ☒ Хүүхдийг ямар нэг байдлаар нь ялгаварлан харилцах

Долоо. Ажилтнуудыг эцэг эхийн үүргээ биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх

7.1.Эцэг эх болон хүүхэд асран хамгаалагч ажилтнуудад эцэг эхийн үүргээ биелүүлэх, хүүхдэдээ халамж анхаарал тавих боломжийг олгох талаар анхаарч ажиллана.

7.2.Хүүхэдтэй холбоотой яаралтай асуудлаар эцэг эх болон асран хамгаалагчид цалинтай чөлөө олгоно.

7.3.Байгууллага нь гэр бүл, эцэг эхийг дэмжих, туслах талаар хөтөлбөртэй байна.

Хавсралтууд

Хавсралт 1. Тодорхойлолтын загвар

Хавсралт 2. Хүүхэд хамгааллын Ёс зүйн дүрмийг хүлээн зөвшөөрсөн гэрээ

Хавсралт 1.

**ЗАН БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ ГАРГУУЛАХ ХҮМҮҮСИЙН ХАЯГ БОЛОН
ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДОЖ БАЙСАН ЭСЭХЭЭ ШАЛГУУЛАХ ТУХАЙ**

Зан байдлын тодорхойлолт гаргах хүмүүс

Таны зан байдлын талаар тодорхойлолт өгөх боломжтой таныг 2 жилээс дээш хугацаагаар таних 2 хүний нэр, холбоо барих хаягийг бичнэ үү! (Гэр бүлийн гишүүдийг оруулахгүйгээр)

Тодорхойлогч 1:

Нэр:	
Гэрийн хаяг:	
Утас, мэйл	

Тодорхойлогч 2:

Нэр:	
Гэрийн хаяг:	
Утас, мэйл	

Та өмнө нь гэмт хэргийн улмаас ял шийтгэл эдэлж байсан уу?

Тийм Үгүй

Хэрвээ тийм бол ял шийтгэлийн талаар бичнэ үү?

(Энэхүү мэдээллийг задруулахгүй бөгөөд Хүүхэд хамгааллын хувьд ямар нэгэн эрсдэл байгаа эсэхэд байгууллагын удирдлага үнэлгээ хийхэд ашиглах юм.)

--

Хавсралт 2.

Хүүхэд хамгааллын Ёс зүйн дүрмийг
хүлээн зөвшөөрөх тухай

20 .. оны .. сарын өдөр

Дугаар:

..... овогтой би
энэхүү байгууллагын Хүүхэд хамгааллын бодлогод дурдсан ёс зүйн дүрмийг уншиж
ойлголоо. Би энд дурдсан зарчмуудыг хүлээн зөвшөөрч энэ байгууллагад ажиллаж байх
хугацаандаа хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийг хэрэгжүүлэн ажиллана.

.....
(Овог нэр)

.....
(Албан тушаал)

.....
(Гарын үсэг)

Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018
оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт



**БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖИЙН ДЭРГЭД
ЭЦЭГ, ЭХИЙН ЗӨВЛӨЛ БАЙГУУЛЖ
АЖИЛЛУУЛАХ ЗӨВЛӨМЖ**

**БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖИЙН ДЭРГЭД
ЭЦЭГ, ЭХИЙН ЗӨВЛӨЛ БАЙГУУЛЖ
АЖИЛЛУУЛАХ ЗӨВЛӨМЖ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенци, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйл, Гэр бүлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 28, 29 дүгээр зүйл, 2018 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын 01 албан даалгавар, 2017 оны Засгийн Газрын 270 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт, Мөн Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А/027, А/047, А/35 дугаар тушаалаар батлагдсан “Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгагдсан:

- Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангасан хүүхэд ээлтэй орчин бүрдүүлэх
- Эцэг эх, асран хамгаалагч, олон нийтэд, хүүхдийг асрах, хүмүүжүүлэх, мэдлэг, хандлага, төлөвшүүлэх
- Нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс хамгаалах,
- Хүүхдийг аливаа эрсдэлд өртөх, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхээр бүх яам, агентлаг төв болон харьяа байгууллага, орон нутгийн нэгжүүддээ эцэг эхийн зөвлөл байгуулж, ажиллуулна гэсэн зорилтуудын хэрэгжилтийг хангах.

Хоёр. Эцэг эхийн зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт

2.1.Эцэг эхийн зөвлөл гэж (цаашид “Зөвлөл” гэх) нь хүүхдийн сурч боловсрох, эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэх, соён гэгээрүүлэх, хүүхдэд ээлтэй байгууллага хамт олныг бий болгоход дэмжих, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд хөндлөнгийн хяналт тавих, гэр бүлийн тогтвортой байдлыг хангах, байгууллагын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх үүднээс тухайн байгууллагаас эрх үүрэг хүлээж албан ёсоор томилогдсон хамт олны төлөөллөөс бүрдсэн зөвлөлийг хэлнэ.

2.2.Зөвлөлийг хамт олны санал санаачлагад тулгуурлан байгуулна. Зөвлөлийг байгууллагын нийт ажиллагсдын тооноос хамаарч 3-9 хүртэл хүний бүрэлдэхүүнтэй 2 жилийн хугацаатай байгуулна.

2.3.Зөвлөл нь дарга, тэргүүлэгч, нарийн бичгийг анхны хуралдаанаараа хэлэлцэж, олонхийн саналаар баталж, томилно.

2.4.Байгууллага нийгмийн хариуцлагаа ухамсарлаж эцэг эхийн зөвлөл байгуулах санаачилгыг дэмжих, хамтран ажиллах үүрэгтэй. Энэ үүргийн хүрээнд Зөвлөлийн дарга нь байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажиллана.

2.5.Зөвлөлийн нарийн бичиг нь өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, улирал тутамд зөвлөлд үйл ажиллагаагаа тайлагнаж ажиллана.

2.6.Зөвлөлийн бүрэлдэхүүнд байгууллагын албан хаагчдын санал, хүсэл эрмэлзлийг төлөөлөн ажиллах ахмад, залуу үеийн төлөөлөл орно.

2.7.Зөвлөлийн гишүүд нь "Хүүхэд хамгааллын бодлого"-той танилцаж, гарын үсэг зурж хүлээн зөвшөөрсөн байна.

2.8.Зөвлөл нь сард 1 удаа хуралдах ба шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөт бус хурал хуралдаж болно.

2.9.Зөвлөл хийх ажлынхаа төлөвлөгөөг 1 жилийн хугацаатайгаар гарган хурлаар батална.

2.10.Зөвлөлийн хуралдааныг тэмдэглэл хөтөлж, зөвлөлийн дарга, нарийн бичиг, тэмдэглэл хөтөлсөн хүн гарын үсэг зурж баталгаажуулна.

2.11.Гишүүдийн гуравны хоёроос доошгүй ирцтэй үед зөвлөлийн хурлыг хүчин төгөлдөрт тооцож, асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэх ба санал тэнцсэн тохиолдолд зөвлөлийн даргын саналаар шийдвэрлэнэ.

Гурав. Зөвлөлийн үйл ажиллагаа

3.1.Байгууллагын эцэг эхийн зөвлөл зохион байгуулалтын хувьд тухайн байгууллагын ажилтан, албан хаагчдын гэр бүл, хүүхдийн судалгаанд үндэслэн тэдэнд чиглэсэн үйл ажиллагааг үе шаттай төлөвлөн зохион байгуулж, байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ, үйлдвэрлэл, бүтээгдэхүүнээр хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих талаар удирдлагатай хамтран ажиллана.

3.1.1. Гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр

- 1) Гэр бүлийн харилцаа, төлөвлөлт, гэр бүлийн үүргийн талаар лекц, сургалт зохион байгуулах.
- 2) Өөрийн байгууллагын албан хаагчдад хүүхдийн нас бие сэтгэхүйн онцлогийг таньж мэдэх, хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга эзэмшүүлэх сургалтуудыг зохион байгуулах.
- 3) Залуу болон анхаарал шаардлагатай гэр бүлд зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд мэргэшсэн байгууллага, ажилтнуудтай хамтран ажиллах, Гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийн үйлчилгээнд хамруулах.
- 4) Угийн бичиг хөтөлдөг гэр бүлийг хамт олондоо сурталчлах, үндэс, гарал язгуураа мэдэж байхын ач холбогдлыг ойлгуулах үйл ажиллагаа зохион байгуулах.
- 5) Хүүхэд, гэр бүлийн эсрэг хүчирхийллийн талаарх мэдээллийг холбогдох байгууллагад мэдэгдэх
- 6) Байгууллагын ажилтны тоо, цар хүрээ, боломжид тулгуурлан байгууллагын дэргэд хүүхдийн өдөр өнжүүлэх, цэцэрлэг байгуулж ажиллуулах талаар санаачлагатай ажиллах.
- 7) Байгууллагын онцлогт тохируулан өсвөр насны хүүхдүүдэд чиглэсэн мэргэжил сонгох, ажил хөдөлмөрийн чиг баримжаа олгох, эцэг, эхийн ажилладаг ажлын байр, ажлын онцлог, давуу талыг нь танилцуулах
- 8) Бага насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд хүүхдийг хэрхэн асрах талаар эрүүл мэндийн сургалт зохион байгуулах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх ажлыг мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгуулах.

3.1.2. Хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр

- 1) Ажилтан, албан хаагчдыг хүүхэдтэйгээ хамт чөлөөт цагаа өнгөрүүлэх боломжийг нэмэгдүүлэх ажлыг хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохируулан аялал, гэр бүлийн зуслан, өдрийн

амралт зэрэг гэр бүлд ээлтэй бодлого баримтлах /гэр бүлийн амралт, өдөрлөг гэх мэт/.

- 2) Гэр бүлүүдийн дунд хамтарсан тэмцээн уралдаан зохиох, эрүүл, зөв зан үйлтэй гэр бүлийг бий болгоход санаачлага гаргах.
- 3) Байгууллагын нэр хүндтэй, үлгэр дууриалал болсон гэр бүлийн нэрэмжит тэмцээн, уралдаан зохион байгуулах.
- 4) Олон улс, тив дэлхий, улсын чанартай уралдаан тэмцээнд оролцож амжилт гаргасан хүүхдэд байгууллагын нэрэмжит тэтгэлэг олгох, дэмжлэг үзүүлэх.
- 5) Хүүхдэд эх оронч сэтгэлгээ, зөв хүмүүжил төлөвшил олгох зорилгоор жилд нэг удаа “Миний хүүхэд Монголын ирээдүй” сэдэв дор нөлөөллийн ажил зохион байгуулах.
- 6) Ажилтан, албан хаагчдад өөрийнхөө хүүхдийн сурлага, сурч буй орчинтой танилцан, хариуцан ажиллаж байгаа багш, удирдлагуудтай уулзах боломжийг бүрдүүлэх.

3.1.3. Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр

- 1) Албан хаагчдад Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийг сурталчилах.
- 2) Зөвлөл нь гишүүдээ гэр бүл, хүүхэд хамгааллын сургалтанд үе шаттайгаар хамруулах бөгөөд тухайн байгууллагын нийт эцэг эхчүүдийн тээврийн хэрэгсэл дээр батлагдсан загварын дагуу “Хүүхэд зорчиж байна” наалтыг /авто машины арын шилний баруун доод буланд байрлуулна/ наах, хүүхдийн автомашины суудлыг байгууллагын албан хаагч бүр машиндаа авч явах уриалгыг гарган хэрэгжүүлэхэд анхаарах.
- 3) Гэр бүлийн цахим хэрэглээ болон цахим орчин дахь хүүхдийн мэдээллийн аюулгүй байдлын талаар мэдээллийг ажилтан, албан хаагчдад өгөх, онлайн орчинд хяналт тавьж хүүхдийн эрх ашгийг зөрчсөн мэдээллийн талаар холбогдох байгууллага /Цагдаа, Эрүүл мэнд, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар/-д мэдэгдэх.
- 4) Сайн дурын байгууллага болон тухайн байгууллага ажилтан, албан хаагчдынхаа хүүхдүүдэд хандив тусламж өгөх, нийгмийн хариуцлагын хүрээнд сайн дурын ажил зохион байгуулсан тохиолдолд хүүхдийг олон нийтийн өмнө онцгойлон нэрлэхээс татгалзах /амьдралын түвшин, бие, сэтгэцийн өөрчлөлт зэргийг тусгайлан онцлох/, Хүүхдийн тухай мэдээллийг мэдээллийн хэрэгсэл, нийгмийн /Facebook, Instagram, Youtube гэх мэт/ сүлжээнд ил тод зарлахгүй байх
- 5) Эцэг эхчүүд хүүхдийн өмнө хүлээх үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор цэцэрлэг, бага ангийн хүүхэдтэй эцэг эхчүүдэд Хөдөлмөрийн хуулийн дагуу богиносгосон цагаар ажиллах нөхцөл бүрдүүлэх, хүүхдийнхээ эцэг эхийн хуралд оролцох, эцэг эхийн эргүүл хийх боломжоор хангах.
- 6) Сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөөг Хүүхдийн тусламжийн 108 утсанд хандан авах талаар эцэг эхчүүдэд мэдээ, мэдээлэл сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах.
- 7) Байгууллагын үйл ажиллагаа, үйлдвэрлэл, бүтээгдэхүүн нь хүүхэд хамгааллын бодлого, зарчмыг дэмжсэн байх

3.2. Зөвлөлийн үйл ажиллагаанд идэвхи санаачлага гарган ажилласан ажилтан, албан хаагчдыг байгууллагын зүгээс урамшуулан дэмжих, холбогдох байгууллагуудад шагналд тодорхойлох.

3.3.0-18 насны хүүхэдтэй гэр бүлийг дэмжих төлөвлөлтийг жил бүр хийж хэрэгжүүлэхдээ албан хаагчдын дунд ярилцлага, хэлэлцүүлэг хийх, ажилтнуудын саналыг нээлттэй авах байдлаар зохион байгуулах.

3.4.Үйл ажиллагааны төлөвлөлт, зарцуулах санхүүжилтийг байгууллагын хамт олны хуралд танилцуулна.

Дөрөв. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын чиг үүрэг

4.1.Тухайн байгууллагын эцэг эхийн зөвлөлөөс 1-2 эцэг эхийн төлөөллийг хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр сургалтанд хамруулж сургагч багшаар бэлтгэх ажлыг үндэсний хэмжээнд хариуцан зохион байгуулах.

4.2.Жилд нэгээс доошгүй удаа эцэг эхийн зөвлөлийн дарга, нарийн бичиг, гишүүдийн уулзалтыг аймаг, нийслэл, сум хорооны түвшинд зохион байгуулж, мэргэжил, аргазүйн удирдлагаар хангах.

4.3.Зөвлөлийн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлж, хийсэн ажлын үр дүн ололт амжилтыг орон нутгийн Хүүхдийн төлөө зөвлөл болон Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлд танилцуулах.

Тав. Үр дүнг нэгтгэх, хянах, төсөв

5.1.Эцэг эхийн зөвлөлийн хийсэн ажлын тайланг жил бүр хамт олны хуралд танилцуулж санал, хүсэлт авч ажиллана. Энэхүү тайлангийн үр дүнгээс хамаарч дараа жилийн үйл ажиллагаанд зориулах төсөв хөрөнгийг батлуулж болно. /Байгууллага хамтын ажиллагааны гэрээний хүрээнд санхүүжилт хийнэ./

5.2.Хүүхдийн хөгжлийн төлөө хийсэн ажил, түүний чанар, үр нөлөө, зарцуулж байгаа төсөв хөрөнгийн зарцуулалтыг жил бүр тооцож ажиллана.

5.3.Жилийн үйл ажиллагааны тайлангаа Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 12 дугаар сарын 01-ний дотор ирүүлж байна.

5.4.Эцэг эхийн зөвлөлийн зөвлөмжийг тухайн байгууллага өөрсдийн онцлог, бүтэц, зохион байгуулалт, ажилтны санал санаачилгад тулгуурлан ямар ч хэлбэрээр өөрчилж шинэчилэн, мөрдөн ажиллаж болно.

Зургаа. Зөвлөлийн үйл ажиллагаа явуулахад баримталж ажиллах эрх зүйн баримт бичгийн жишиг

- 1) Хүүхдийн эрхийн тухай конвенц
- 2) Гэр бүлийн тухай хууль
- 3) Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тухай хууль
- 4) Хүүхдийн эрхийн тухай хууль
- 5) Хүүхэд хамгааллын тухай хууль
- 6) Төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого
- 7) Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого
- 8) Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр /2017-2021 он/
- 9) Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө /2018-2019 он/
- 10) Угийн бичиг хөтлөх журам /Засгийн газрын 2007 оны 257-р тогтоолоор батлагдсан/
- 11) Засгийн Газрын 2018 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн “Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах тухай” 01 тоот албан даалгавар